

МОНГОЛ ДАХЬ ХЯТАД СУДЛАЛ

*Н.Ариунгуа (Ph.D)**

*Ч.Батцэцэг (Ph.D)***

Монгол улс нь Хятадтай хаяа хаяагаа дэрлэн оршдогийн хувьд эрт дээр үеэс Хятад улсыг судалж ирсэн юм. Хятадын соёл иргэншлийн талаархи монголчуудын мэдлэг нь Хятад улстай харьцах практик үйл явцын үр дүнд бий болохын зэрэгцээ Монголын бичгийн хүмүүс Хятадын түүх, уран зохиол, гүн ухаан, төрийн бодлогыг судалсаар иржээ. Хятад орны талаархи энэхүү ойлголт, мэдэгдэхүүн нь үе дамжин баяжигдсаар Хятадын соёл иргэншлийн талаар нүүдэлчин монголчуудын дунд нэгэн цогц ойлголтыг бүрэлдүүлэн бий болгосон байна.

Монгол оронд бүр Кидан гүрний үед эртний Хятадын “Таван бичиг” болох “Зурхайт ном”, “Шүлэглэлт ном”, “Шашинт ном”, “Ёслолт ном”-ыг орчуулсан (Г.Сүхбаатар. “Сяньби”) байх бөгөөд Монголын Юань гүрний үед Хубилай сэцэн хаан 1264 онд Хятадын сонгодог зохиол орчуулах ба түүх зохиох хороог байгуулсан байна. Энэ үед “Дөрвөн ном”, Сыма Гуаны (Хятадын эртний нэрт түүхч) “Цзыжи тунцзянь” (“Төрийг жолоодоход тус болох бүхнийг толилуулагч их судар”) зэргийг орчуулсан байна. Мөн Монголын нэрт бичгийн хүн Болдтөмөр чинсан 1307 онд Күнзийн “Ачлалт ном”-ыг орчуулсан юм. Энэ тухай Бямбын Ринчен ийнхүү хэлсэн байдаг: “Их Юань улсын үеэс тэр нэрт бичгийг монголчууд орчуулсан нь монгол хэл бичгийн өндөр хөгжлийг үзүүлж, европ хэлэнд орчуулахаас нь хэдэн зуун жилийн өмнө монгол хэлнээ тийм бичиг орчуулах нэр томъёоны зэрэг сүрхий хөгжилтэй байсныг үзүүлжээ. Монголчууд Юань гүрний үеэс энэхүү алдарт бичгийг маш сүрхий орчуулж модон бар гаргасныг шинжлэх ухааны гүйлгээнд оруулсан нь монголын эрдэмтний чухал нэмэр болно” гэжээ.¹ Энэхүү “Ачлалт” номын монгол орчуулгыг эрдэмтэн Х.Лувсанбалдан гэрэл зургийн хамт хожуу нийтлүүлсэн байдаг. Эртний монгол нанхиадч нар “Дөрвөн ном”, “Таван бичиг”-ийг орчуулахаас гадна тэдгээрт тайлбар хийж байжээ. 1921 оны хувьсгалын өмнө зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичигт төрийн сургуулийн сурах бичгийн зүйлд урд эрдэмтний уламжилсан Таван ном, Дөрвөн бичиг гэж заан дурьдсан

* Н.Ариунгуа - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

** Ч.Батцэцэг - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

тул, манж хэлтэй зарим багш нар, Дөрвөн бичиг, Их суртахуй, Ер дунд гэх зэргийн бичиг уншуулж, Шүлэглэлт ном, Ачлалт номоос бага сага тайлбарлаж байсан байна.² Манж Чин улсын үед хятад хэлнээс олон арван зохиол орчуулжээ. Тэдгээрээс дурьдваас, “Хүйтэн уулын бичиг”, “Гурван улсын бичиг”, “Тансан ламын тууж буюу Баруун этгээдэд зорчсон бичиг”, “Зин Пин Мэй”, “Хувилгаан өргөмжилсөн бичиг” хэмээх роман, “Эрт өдгөөгийн гайхамшигт үзэгдэл буюу Зин гүцигуань”, “Ши мэргэн ноёны түүх”, “Жийдаан хуушааны тууж”, “Зүүн Баруун Хан улс”, “Их Тан улсын үүсгэлийн бичиг” зэрэг олон чжуан (дэвтэр) бичиг гэх мэт. Их бичгийн хүн Ринчен гуай тэр үед монголын нанхиадч нарын сонгон орчуулсан ном бичиг нь аль дайралдсан буюу хялбар хөнгөнийг авч орчуулсан зүйл огт биш, бүгд учиртай бөгөөд цаг үеийн шаардлага, “нийгмийн захиалга” гэж үзэж болмоор байгааг дурьдаад, Ар Монгол манжийн талхин дороос гарах цаг айсуу гэж Хэвт ёсны эхээр шивир авир хэлэлцэж байх үес Хүрээний Наймаа хотын Балданцэрэн зайсан нар, нанхиадын алдарт түүхэн роман “Хүйтэн уулын бичиг” гэдгийг орчуулсан нь эртний Сүн улсын үес төрий нь донсолгосон тариачин олны сүртэй өргөн их бослогын роман байжээ. Түүний тэр өөсөөн засах улс болохын өмнө орчуулсан нь далдын учир байж, төрийн ёс харгис нь хэтэрсэнд, түмэн тариачин жигшин босгоосныг үзүүлсэн тэр романыг монгол болгосон нь манжийн төрийг жигшин үзэгч олны хорслын галд тос өргөсөн санаа байжээ. Мөн тэрхүү зохиолыг маш сайхан орчуулсан гээд олонд хэрэгтэй гэж орчуулсаныг уншин үзсэн улс их л сонирхон, дам дам бөлөг бөлгөөр нь ярин хүүрнэдэг хүн ч байжээ” гэжээ.³ Ийнхүү монголчууд Хятадын эртний зохиолыг монгол хэлнээ хөрвүүлэн уншиж байсан бөгөөд “уйльяа гэвэл “Саран хөхөө”, уярьяа гэвэл “Ушаандарь”, санаа муутай больё гэвэл “Сан гуо” (“Гурван улсын түүх”), сайн аалит больё гэвэл “Сувашид” үз” гэж урьдын улс ярьдаг байжээ. Нанхиад зохиолуудын монгол орчуулга нь Монголын улсын номын сан, Герман улсын Марбург, Лейпциг, Оросын Санкт-Питербург хотноо, Копенхагены вангийн номын санд тус тус хадгалагдаж байгаа ажээ. Гадаадын нэрт эрдэмтэд хятад сонгодог романы монгол орчуулгын талаар судалгаа хийсэн байдаг бөгөөд тэдгээр нь германы нэрт нанхиадч В. Грубе, хэл шинжлэлийн эрдэмтэд Э.Хэниш, Э.Хэйссиг, оросын эрдэмтэн Рифтин зэрэг юм. Ийнхүү хятадын сонгодог зохиолуудыг ахмад нанхиадч нар “нойроо гээж, идээнийг умартан, нэмэж хасан найруулхуй дор” орчуулсан нь өдгөө дэлхийн нэрт эрдэмтдийн судалгааны сэдэв болсон байна.

Дундад эртний монголчууд Хятад монгол хэлний толь зохиож байснаас дурьдвал, Пагва ламын зохиосон дөрвөлжин үсгээр нанхиад үгийг тэмдэглэсэн “Монгол зы юн” толь байх бөгөөд тэр дөрвөлжин үсгээр хятад үсгийн аялгууг тэмдэглэсэн учир Юан улсын үед хятад үсгийн дуудлага ямар байсныг судлахад их ач тустай толь ажээ. Мөн “Хааны бичсэн манж монгол хятад үгийн гурван зүйлийн аялгуу нийлсэн толи бичиг” (32 дэвтэр) хятад үг үгсийг монгол үсгээр дуудлагыг галиглаж хадсан нь монгол үсгийн зөв бичих зүйн ёсоор хятад үг нэр зэргийг хэрхэн галиглахын журмыг тов тод үзүүлснээрээ онцлог ажээ.

Эрт дээр үеэс Монголын эрдэмтэн мэргэд Хятадын эртний судар бичгийг судалж байсны бас нэг жишээ бол түүхч Рааш Пунцаг Хятадын төрийн түүхийг уншин судалж, Хятадын түүх бичлэгт нүүдэлчин монголчуудыг хэрхэн тусгаж байсанд шүүмжлэлтэй хандснаас тодорхой. Тэрээр: “Хятадын сударч гэх мэргэд бээр гагцхүү өөрийн улсын судраа тэмдэглэхийн завсарт зах өнцөг өчүүхэн дайрагдан гарсныг авч, харин ч бийрийн зөөлөн үзүүрт шүтэж өөрийн аймгаа сэмээр магтсан ба бусдыг нарийнаар доромжилсон зүйлгүй гэж үл болно” хэмээн Хятадын сурвалж бичигт шүүмжлэлтэй хандахыг зөвлөсөн байдаг.

Ийнхүү монголчууд Хятадын түүх, соёл, төрийн бодлогыг судалсаар байсны үр дүнд Хятадын соёл иргэншлийн талаар тодорхой ойлголт бүрэлдэн бий болсон байна. Монголчуудын үеийн үед хуримтлуулсан Хятадын талаархи мэдэгдэхүүн, ойлголт нь өнөөг хүртэл ач холбогдлоо алдаагүй байгаа нь Хятадын нийгмийн өөрийнх нь онцлогтой холбоотой юм. Энэ талаар хятад гаралтай Америкийн эрдэмтэн Лю Учи маш оновчтой хэлсэн байх нь: “Хятадын нийгмийн багагүй ойлголт XX зуун хүртэл амь бөхтэй оршсоор байгаа нь Хятадын нийгмийн сэтгэл зүйн хүчин зүйл болох Күнзийн сургаал нь Хятадын ард түүмний түүхэн хувь заяа болон үндэсний шинж чанартай гайхалтай нийцсэнтэй холбоотой”⁴ гэжээ.

Шинэ үеийн Монголын Хятад судлал XX зууны дунд үеэс эхэлсэн болно. 1949 онд БНХАУ байгуулагдснаар Монгол-Хятадын харилцаа идэвхтэй хөгжиж, хоёр орны харилцаа урьд өмнө байгаагүй харилцааны шинэ хэлбэрт орсноор хятад хэлтэй хийгээд Хятадаар мэргэжсэн боловсон хүчин нэн шаардлагатай болов. Иймээс Монголын төрөөс хятад хэл, хятад судлалаар боловсон хүчин бэлтгэх зорилгоор хэдэн залуусыг Хятадын их дээд сургуульд илгээсэн юм. Тэдгээр залуус Хятадад боловсрол олж ирснээр Монголд шинэ үеийн анхны хятад судлаачид төрөв. (Ч.Далай, Чой.Лувсанжав, Д.Бандихүү, О.Адьяа, Л.Манлажав).

Улмаар МУИС-д 60-аад оны эхэн үеэс анх Хэл бичгийн факультетэд монгол хэл утга зохиол, орос хэлний багш бэлтгэхийн зэрэгцээ түвд, манж, хятад, англи, франц, герман хэлний багш орчуулагч, утга зохиолын ажилтны найруулагчийн ангиуд нээж оюутан элсүүлэн сургажээ. МУИС-ийн хятад хэлний ангийг анх 14 оюутан хятад хэлний мэргэжлээр төгсөж байжээ. Анхны хятад хэлний багшаар Бээжин их сургуулийг төгсгөсөн Чой. Лувсанжав, БНХАУ-аас ирсэн багш Лю Лин түүний хэлмэрч багш Ө.Гүрсэд нар хичээл заадаг байжээ. Дараа дараагийн жилүүдэд БНХАУ-д их сургууль төгсгөж ирсэн шинэ залуу боловсон хүчин Р.Нямаасүрэн, О.Адьяа, Л.Манлажав, Ч.Далай гэсэн багш нар Хятад хэл, хятадын уран зохиол, хятадын түүхийн хичээл заадаг байв. Тухайн үед монголын анхны хятад судлаачид их дээд сургуульд хятад хэл заах, хятадын уран зохиол орчуулах, хятад хэлний ярианы дэвтэр зохиох ажлыг хийсэн юм. Тухайлбал: Ө.Гүрсэд “Монгол-хятад хэлний ярианы дэвтэр”-ийг 1957 онд хэвлүүлсэн нь тухайн үеийн хятад хэл эхлэн суралцагсдад гарын авлага болж байлаа.

1960-аад оны үед Хятадын уран зохиол, ялангуяа хятадын шинэ үеийн уран зохиолын нэрт төлөөлөгч Лу Синь зэрэг зохиолчдын зохиолыг орчуулж монгол уншигчдад танилцуулсанд шинэ нийгэм бүтээн босгож буй Хятад орны талаар монголчуудын сонирхолыг ихэд татсан юм. Тухайлбал: Д.Бандихүү, Чой.Лувсанжав нар Хятадын их зохиолч Лу Синий “Мөнх гийгүүлэгч дэнлүү”, “Нохойн бооролт”, “Гуйлгын эзэн”, Лу Синий 1927 оны 4- дүгээр сарын 8-нд Хуанпугийн цэргийн дарга нарын сургуульд уншсан лекц, “Түмэн газрын цагаан хэрэм” зэрэг 15 өгүүлийг хятад хэлнээс монгол хэлнээ орчуулж “Мөнх гийгүүлэгч дэнлүү”⁵ нэртэйгээр нийтэлсэн байна. Тус түүвэрт орсон Лу Синий “Түмэн газрын цагаан хэрэм” хэмээх богинохон боловч маш утга төгөлдөр өгүүлийг нанхиалч Д.Бандихүү ийнхүү маш сайхан орчуулсан байх нь: “Түмэн газрын их хэрэм минь! Газрын зураг дээр нарийхан зурвасаар тэмдэглүүлсэн чамайг, энэ дэлхийн хаана ч бага ч атугай мэдлэг сурсан хүн бүр андахгүй биз ээ. Чиний төлөө үеийн үед хичнээн хөдөлмөрч хүмүүс амь насаа алдаа вэ! Нүүдэлчин аймгийн довтолгооныг тогтоон барьж чадах уу чи? Одоо зөвхөн эртний дурсгалт зүйл болон үлджээ. Баларч арилахгүй нь мэдээж болов уу, эсхүл хамгаалуулан үлдэх нь юуны магад...” гэжээ.⁶ Мөн орчуулагч Ж.Артөр Хятадын их зохиолч Лу Синий “Галзуу хүний өдрийн тэмдэглэл”, “А Кьюгийн үнэн түүх”, Ө.Лодойдамба Го Можогийн “Шанхайн өглөө”, Ө.Гүрсэд Мао Дуний “Үнэгэн харанхуйд,” орчуулагч Д.Дүнгэр-Яйчил Ба Зиний “Гэр бүл,”

орчуулагч Б.Бат Жоу Либогийн “Догшин салхи, ширүүн бороо” гм зохиол, “Буурал бүсгүй”, “Тэд тулалдаан дунд өссөн юм” зэрэг уран сайхны кино, “Хятадын хошин яриа, үлгэр” орчуулж олны хүртээл болгож байлаа. Ийнхүү монголчууд хятадын уран зохиолыг ихээр орчуулахдаа заримыг нь ахуй байдалдаа зохицуулан өөрчилж, өөрийн болгон шингээх ажлыг мөн нэгэн адил хийж иржээ. Монгол үлгэрч, хуурч нарын өгүүлэн хайлдаг бэнсэн үлгэрүүд болон “Молом тойн намтар” зэрэг нь хятадын зарим романыг өөрчилж монголчилсон үлгэрүүд болно.

Гэвч өгүүлж буй үед хятад судлалын ажил эхлэлийн төдий байсан бөгөөд хятад хэлтэй боловсон хүчинг эх орондоо бэлтгэх, хятадын уран зохиолыг орчуулах, хятад хэлний ярианы толь зохиох хэмжээнээс хэтрээгүй юм.

Монгол дахь хятад судлал харьцангуй эрчимтэй хөгжиж ирсэн үе бол XX зууны 70 -аад оны үе бөгөөд энэ үеэс Монголд албан ёсоор хятад судлалаар мэргэшсэн боловсон хүчин - хятад судлагч, орчуулагч, багш, эрдэмтэд бэлтгэж эхлэв. 1960-аад оны дунд үеэс МУИС-ийн Хятад хэлний сургалт арваад жил завсарласны дараа 1973-1974 оны хичээлийн жилд Монгол хэл бичгийн ангийн оюутнаас цөөн хэдэн оюутанд хятад хэлийг сонгон суралцуулж эхлээд, 1975 онд МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны тогтоолоор МУИС-д хятад хэлний ангийг тэр үеийн гадаад хэлний тэнхимийн харьяанд нээсэн байна. МУИС-ийн Гадаад хэлний тэнхимийн эрхлэгчээр Чой.Лувсанжав профессор ажиллаж, шинээр нээсэн хятад хэлний ангид багш авах, оюутан элсүүлэх, ном сурах бичиг, гарын авлагатай болгох талаар хичээнгүйлэн зүтгэж байлаа. Чой.Лувсанжав багш “Монгол хятад ярианы дэвтэр” 1, 2-р дэвтэр хэвлүүлсний сацуу Монголын орчин цагийн орчуулгын онолд үнэтэй хувь нэмэр оруулж “Орчуулагч нар анхаарууштай гурван зүйл”, “Орчуулгад хэлбэр судлалын аргыг хэрэглэх нь” зэрэг эрдэм шинжилгээ судалгааны өгүүллүүд бичиж, Монголын Орчуулагчдын Холбооноос эрхлэн гаргадаг “Орчуулах эрдэм” цувралд орчин цагийн Монгол орчуулгын онолд шинэ санаа оноо дэвшүүлсэн, хэлмэрч орчуулагч хэнбугай ч заавал унших үнэ цэнэтэй өгүүлэл нийтлүүлжээ.

1968 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны тогтоолоор Шинжлэх Ухааны Академийн Тэргүүлэгчдийн дэргэд Ази, Африк судлах хэлтэс байгуулж, улмаар 1976 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн Сайд нарын Зөвлөлийн 492 тоот тогтоолоор Дорнодахины судлалын хүрээлэн болгон

судалгааныхаа хүрээг өргөжүүлжээ. Чухамхүү энэ үед манай улс аливаа салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг ЗХУ болон бусад социалист орнуудад сургаж бэлтгэж байсан үе юм. Үүний нэгэн адил манай төр засгаас хятад хэл, хятад судлалын чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэхэд ихээхэн анхаарал тавьж, аль хэрэгцээт яам, албан газруудаас захиалга авч тухайн байгууллагын нэр дээр ЗХУ-д оюутан сургаж, хожим БНХАУ-д даллага хийлгэх, мэргэжил дээшлүүлэх болов. Тухайлбал: эрдэм шинжилгээ-судалгааны гол цөм болсон ШУА-ийн захиалгаар бэлтгэгдсэн хятад судлаачдын тоонд өнөөгийн эрдэмтэн судлаачид Н.Алтанцэцэг, Н.Ариунгуа, Ж.Баясах, Ц.Батбаяр, Ч.Батцэцэг, Д.Наран нарыг багтаан нэрлэж болно.

Мөн МУИС-ийн Хятад хэлний ангийг төгсгөсөн дээд боловсролтой мэргэжилтнүүдээс өнөөдөр А.Дамдинсүрэн, Ц.Базаррагчаа, Д.Баясгалан, Л.Бэгзжав, Д.Шүрхүү, Я.Ганбаатар, Ч.Таамаа, М.Чимэдцэеэ, Д.Болдбаатар, Ц.Эгшиг, В.Батмаа нарын олон хүн Хятад судлалын чиглэлээр ажиллаж эрдмийн зэрэг, цол хүртжээ.

Чухамхүү энэ үеэс эхлэн хятад судлалын ажил шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулагдсан юм. Тухайн үед хятад судлалын ажил бие даасан институтын хэмжээнд зохион явагдах болж хятад судлал гол төлөв ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэн, МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн ухааны Институт зэрэгт төвлөрч байв. Хятад судлал шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжих явдал Хятадад өрнөсөн “Соёлын хувьсгал”-ын үетэй (1965-1974) таарсан учир хятад судлал чухамхүү Хятад дахь энэхүү хэрэг явдал руу чиглэсэн юм.

Тухайн үед “Соёлын хувьсгал” хэмээх балмад үйл явдлын мөн чанарыг илчлэн олон түмэнд таниулах явдал хятад судлалын гол зорилго чиглэгдэж байв. “Соёлын хувьсгалын” үед Хятад улс манай улсын талаар илт дайсагнасан бодлого явуулж, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс оролцох, манай улсын түүхийг илтээр гуйвуулан түүхээсээ аваад Хятадын салшгүй нэг хэсэг байсан мэт судалгаа сурталчилгааны ном зохиолууддаа бичиж байв. Иймээс хятад судлаачид “соёлын хувьсгал”, маоизмын мөн чанарыг илчлэн харуулах, Хятад улсын зүгээс манай улсыг ямар ч үндэслэлгүйгээр бүдүүлгээр дайран довтлох, илтээр түүхийг нь гуйвуулах явдалд хариу няцаалт өгөхөд чиглэгдэж байв. Энэ чиглэлээр Монголын хятад судлаачид олон арван судалгаа сурталчилгааны өгүүлэл, шүүмж, хэд хэдэн бие даасан нэгэн сэдэвт судалгааны зохиол туурвисан юм. Тэдгээрээс зарим нэгийг нь дурьдваас: “Маоизм ба маогийнхан” (УБ. 1974, 1976, 197.ред

Н.Ишжамц, Д. Маам), “Хятад дахь хэрэг явдлын тухайд” (УБ.1979 рел. Ч. Далай), “Хятад дахь хэрэг явдлын тухайд /1973-1976/ 1,2 дэвтэр.(Рел. Ч.Далай), Ш.Бира, Н.Ишжамц “Маогийнхан БНМАУ-ын түүхийг гуйвуулж байгаа хийгээд түүхэн бодит байдал” (УБ.1982) гм.

Хятад судлалын нэг чухал судалгааны чиглэл бол БНХАУ-ын цөөнх үндэстний асуудал байв. “Соёлын хувьсгал”-ын үеэр хятадын цөөнх үндэстнүүд ихэд хэлмэгдэж, оюун санаа, бие мах бодийн хүнд дарамтанд ороод байсан юм. Иймээс монголын хятад судлаачид хятадын үндэстний асуудлыг судлахад анхаарлаа хандуулж ялангуяа БНХАУ-ын цөөнх үндэстний өөртөө засах орон хөрш зэргэлдээ Өвөр Монголын өөртөө Засах Орон (ӨМӨЗО), Сынцзын Уйгурын Өөртөө Засах Орон (СУӨЗО) болон Түвдийн Өөртөө Засах Оронд (ТӨЗО) оршин суух хятад биш ард иргэдийн хувь заяа, үндэстний хэл бичиг, соёлын хэлмэгдүүлэлтийн асуудлыг чухалчлан судлах ажлыг эрчимтэй явуулж эхэлсэн юм. БНХАУ-ын үндэстний цөөнхийн өөртөө засах орнуудад явуулж байсан дээрэнгүй бодлого, тухайн үндэстний түүх, нийгэм-эдийн засгийн байдлыг тодорхойлсон ном бүтээл, эрдэм шинжилгээ-судалгааны өгүүлэл, сурталчилгааны өгүүллийг олноор нь хэвлүүлж, цөөнх үндэстний хэл бичиг, түүх, соёлын талаар авч явуулсан арга хэмжээний тухайд өгүүлэл, мэдээлэл бичиж, тэмдэглэж иржээ. Чухам энэ үед Монголд хятадын үндэстний асуудлын талаархи судалгааны чиглэлийн үндэс сүүр тавигдсан гэж хэлж болно. БНХАУ-ын үндэстний асуудлаар манай судлаачид олон арван өгүүлэл, хамтын бүтээл нэгэн сэдэвт зохиол бичиж туурвисан юм. Тухайлбал: “БНХАУ-ын үндэстний зарим автономит районы байдал” (УБ-Прага. 1987) / Монгол-Чехийн судлаачдын хамтын бүтээл/, М.Зэнээ “ӨМӨЗО-ы засаг захиргаа, нутаг дэвсгэрийн өөрчлөлт” (УБ.1981), Д.Маам “Маогийн бодлогод хэлмэгдэж буй Төвд орон” (УБ. 1975), Л.Бэгэжав “БНХАУ-ын Сынцзын Уйгурын автономит район” (УБ. 1984), “БНХАУ-ын ӨМӨЗО” (УБ, 1981), “БНХАУ дахь үндэстний зарим автономит районы байдал (1976-1983)”, М.Зэнээ “Өвөр Монголын ардын аман зохиол” (УБ, 1981) зэргээс гадна тухайн үед эрдэм шинжилгээний ажилтнуудын бичиж нийтлүүлсэн эрдэм шинжилгээ-судалгааны өгүүллүүдээс цөөн хэдийг дурьдвал, М.Зэнээ “Өвөр Монгол дахь соёл, урлагийн одоогийн байдлаас” (“ДДСА” сэтгүүл. 1985, №2/13/), М.Хурметхан, Ч.Батцэцэг “Сынцзын-Уйгурын автономит район дахь хятад биш ард түмний соёлын өв, өнөөгийн байдал” (“ДДСА” сэтгүүл. 1989, №1/20/), мөн “Түвдийн сүм хийд”, “Хятад дахь монгол хэлний өнөөгийн байдал” гэх

зэрэг олон арван өгүүллийг нэрлэж болно. Мөн судлаачид Хятадын “соёлын их хувьсгал”-ын үеийн Хятадын нийгэм, эдийн засгийн хөгжил, хятадын удирдагчдын явуулж байсан дээрэнгүй бодлого, түүний үр дагаврыг үндэстний цөөнхийн бүс нутгийн эдийн засгийн байдалтай уялдуулан ялангуяа хил залгаа, угсаа гарал нэг үндэстнийх нь хувьд голдуу Өвөр Монголын жишээн дээр судлан, нэгэн сэдэвт зохиол бичиж эрдмийн зэрэг хамгаалж байв. Тухайлбал: “БНХАУ дахь “соёлын хувьсгал”-ын үеийн ӨМӨЗО (1966-1977)” нэгэн сэдэвт зохиолыг хятад судлагч А.Дамдинсүрэн бичиж, 1980 онд эрдмийн зэрэг хамгаалсан бол Ц.Батбаяр “Орчин үеийн БНХАУ-ын эрх баригчдаас Өвөр Монголын талаар явуулж буй үндсэн чиглэлүүд (1976-1984) сэдвээр 1987 онд эрдмийн зэрэг хамгаалжээ.

Ийнхүү БНХАУ-д суугаа үндэстний цөөнхийн асуудал Монголын хятад судлаачдын бас нэгэн судалгааны үндсэн чиглэл болж, өнөөг хүртэл үргэлжлүүлэн судлаж байна.

Хятадын “соёлын хувьсгал”-ын үеийн хятад судлалын бас нэг онцлог бол Хятад дахь хэрэг явдлыг олон улсын коммунист хөдөлгөөний хүрээнд судалж байсан явдал юм. Энэхүү чиглэлийн судалгаа нь МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн ухааны институт дээр төвлөрч байв. Энэ чиглэлээр бичигдсэн гол гол бүтээлүүдийн дурьдваас: “Монгол, Хятадын харилцааны талаархи МАХН-ын интернационалч байр суурь” (Өгүүллүүдийн эмхэтгэл, УБ, 1984)

Ийнхүү 1960-аад оны сүүлч 1980-аад оны эхэн хүртэлх Монгол дахь хятад судлал нь улс төр, үзэл суртлын чиглэлээр явагдаж байсан агаад тухайн үед хятад судлал нь багагүй бэрхшээлтэй тулгарч байв. Энэ нь юуны өмнө хятад судлалаар бэлтгэгдсэн боловсон хүчин дутмаг, хятад судлаачид нь хятад хэлний мэдлэггүй эсвэл хангалтгүй байхын зэрэгцээ судалгааны ажил нь тухайн үеийн Монголын улс төрийн нөхцөл байдлаас хамаарч улс төр, үзэл суртлын маш хатуу хяналт дор явагдаж, хятад судлалаар ажиллаж байсан судлаачид ч улс төрийн хэлмэгдэлд өртөх явдал цөөнгүй гарч байсан юм. Өгүүлэн буй үеийн хятад судлалын ажил нь сэдвийн нэлээд явцуу хүрээнд хийгдэж байсан нь мөн дээрхи шалтгаануудаар тайлбарлагдах бизээ. Хэдий тийм боловч чухам энэ үеэс Монголд хятад судлалын бие даасан салбар бий болох үндэс тавигдсан гэж хэлж болно.

Монгол дахь хятад судлал нь Монгол, Хятад хоёр орны харилцааны шинж чанар, улс төрийн нөхцөл байдлаас ихээхэн хамаарч ирсэн бөгөөд 90-ээд онд өрнөсөн Монгол дахь ардчилсан хувьсгал, Хятадад эхэлсэн өөрчлөлт шинэчлэлийн бодлогын үр дүнд

хоёр орны харилцаа хэвийн болж, цаашид эрчимтэй хөгжснөөр хятад судлал ч хөгжлийнхөө шинэ шатанд гарав.

Хятад судлал хөгжихийн хирээр судалгааны чиглэл нэмэгдэж, судалгааны сэдэв улам нарийсч, судлаачдын тоо ч олширсон болно. Хятад судлал идэвхтэй хөгжих болсон нь юуны түрүүнд Хятад улсад өрнөсөн өөрчлөлт шинэчлэлийн бодлого түүний амжилт, Монгол, Хятадын эдийн засаг, худалдааны гол түнш хийгээд Хятад улстай харилцах харилцаа нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болсон зэрэгтэй шууд холбоотой юм.

Өнөөгийн Хятад судлалын чиглэлийг ерөнхийлэн тодорхойлоход: улс төр, эдийн засаг, түүх, хэл шинжлэл, утга зохиол судлал зэрэг болно.

Улс төр эдийн засгийн судалгаа. Энэ төрлийн судалгааны арга зүй, зорилго нь Монгол Улсын эрх ашиг, үндэсний аюулгүй байдлын үүднээс судлахад чиглэгддэг бөгөөд дотроо дотоод, гадаад бодлогод хуваагддаг.

Гадаад бодлогын судалгаа.

Дэлхийн тавцан дээр түүн дотроо бүс нутгийн хэмжээнд Хятад улсын нэр хүнд, оролцоо эрс өссөн, хятадын эдийн засгийн үсрэнгүй хөгжил глобалчлалын үйл явц, манай улсын гадаад улс төрийн идэвхжилт зэрэг нь Хятадыг олон улсын харилцааны хүрээнд түлхүү судлахад хүргэсэн юм. Хятадын гадаад бодлогын судалгаа нь доорхи чиглэлд явагддаг: Хятадын гадаад улс төрийн бодлогын стратеги, цаашдын хандлага, олон улсын аюулгүй байдал ба Хятадын байр суурь, бүс нутгийн хамтын ажиллагаа ба Хятадын оролцоо, хятадын олон талт харилцаа болон хоёр талт харилцаа түүн дотроо Монгол-Хятадын харилцаа гэх мэт. Энэхүү судалгааг гол төлөв Стратегийн судалгааны хүрээлэн, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, МУИС-ийн Олон улсын харилцааны сургуульд тус тус эрхлэн явуулж байна.

1990 оноос Хятадын гадаад бодлогын талаархи судалгаа эрчимжиж эрдэм шинжилгээний олон арван өгүүлэл, хамтын бүтээл хэвлэгдэн гарснаас гадна дотоодын болон олон улсын хэмжээний хурал, симпозиум тасралтгүй зохиогдсоор иржээ. 1994-2006 оны хооронд энэ чиглэлээр Монголдоо эрдэм шинжилгээний өгүүлэл, илтэл олон арваараа хэвлэгджээ. Тухайлбал: Ц.Гомбосүрэн “Үндэсний аюулгүй байдал: гадаад бодлогын зарим асуудлын хоёр хөршийн тухайд” (“Стратеги судлал” сэтгүүл, 2001, №1), М.Батчимэг “БНХАУ-ын стратегийн гадаад орчин ба гадаад бодлогын чиг хандлага” (“Стратеги судлал” сэтгүүл, 2003, №2), Х.Аюурзана “Монгол-Хятадын харилцаа” (“Стратеги судлал”

сэтгүүл, 1999, №1), Н.Алтанцэцэг “90-ээд оноос хойшхи үеийн Орос-Монгол, Хятад-Монголын харилцаа” (“Стратеги судлал” сэтгүүл, 2002, №2), Х.Олзвой “Монгол Улсын талаар явуулж буй БНХАУ-ын геополитикийн зарим асуудал” (“Эрдэм шинжилгээний бичиг” №7 ОУХС, 2001, №4), Д.Шүрхүү “Глобализация и Монголо-китайские торгово-экономические отношения” (“Проблемы Дальнего Востока” 2003, №6), Д.Баярхүү “Олон улсын харилцаа дэлхийн шинэ дэг журам” (УБ, 2000 ном), Ц.Батбаяр “Европын Холбоо ба БНХАУ-ын стратегийн түншлэл” (“Стратеги судлал” 2005, №6), Ц.Батбаяр “БНХАУ-ын хөгжлийн шинэ үзэл баримтлал” (“Өнөөгийн Хятад” сэтгүүл, 2006, №1) гм.

Хятадын гадаад бодлогын судалгааны нэг гол сэдэв бол Монгол-Хятадын харилцааны асуудлаархи судалгаа бөгөөд 90-ээд оноос хойш энэхүү сэдвийн судалгаа харьцангуй хөгжиж хоёр орны улс төр, эдийн засгийн харилцааны талаар хэд хэдэн диссертаци зохиол хийгээд мөн нэлээд хэдэн судалгааны хамтын бүтээл бичигджээ. Тухайлбал: Ч.Далай. “Отношения между КНР и МНР (1949-1984)”, Л.Бэгзжав “Монгол-Хятадын харилцаа (1949-1999)”, Ду Шивэй “Өөрчлөлт шинэчлэлтийн үеийн Хятад-Монголын харилцаа (1980-1995)”, Ч.Батцэцэг “Монгол-Хятадын харилцаанд ӨМӨЗО-ны эзлэх байр суурь (XX зууны дунд үеэс XXI зууны эхэн) зэрэг диссертаци зохиолыг дурьдаж болно. Дээрхи зохиолуудад Монгол-Хятадын харилцааны шинж чанарыг бүхий л талаас нь үечлэн тодорхойлохыг оролдсон байх бөгөөд XX зууны үеийн хоёр орны харилцааны түүхийг ерөнхийд нь тоймлон гаргаснаараа ач холбогдолтой юм. Хамтын бүтээлийн хувьд гэвэл ШУА-ийн ОУСХ-ийн хятад судлалын эрдэм шинжилгээний ажилтнууд (Д.Шүрхүү, Н.Ариунгуа, Ч.Батцэцэг) Монгол-Хятадын эдийн засгийн харилцааны асуудлаар “Монгол-Хятадын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны төлөв байдал” (УБ.2004) хэмээх өгүүллийн эмхэтгэл нийтлүүлсэн байна. Уг эмхэтгэлд Монгол-Хятадын эдийн засгийн харилцааны өнөөгийн байдал цаашдын хандлага төлөвийг урьдчилан тодорхойлж, ялангуяа БНХАУ нь Монгол улсын худалдааны зонхилох түнш болсныг харуулан, Монгол-Хятадын хил орчмын худалдаа, бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа, геологи уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар дахь Хятадын хөрөнгө оруулалт, Хятадын хөрөнгө оруулалттай манай улсын жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн газруудын үйл ажиллагаа зэрэгт судлаачид зохих дүн шинжилгээ хийж Монгол дахь хятадын хөдөлмөрийн хүчний оролцооны асуудлыг чухалчлан авч үзсэн байна. Мөн тус хүрээлэнгийн хятад судлаачид

БНХАУ-ын Өвөр Монголын Зүүн Хойт Ази судлалын хүрээлэнтэй хамтран хоёр орны харилцааны талаар “Эрдэм шинжилгээний өгүүлийн түүвэр” (Хөххот, 2004) хэвлэн гаргасан байна. Мөн Д.Батбаяр “ХХ зууны Монгол Улс, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа” (УБ.2002) хэмээх ном бичжээ. Монгол-Хятадын харилцааг судлах судалгааны гол зорилго бол хоёр талын харилцааг улам төгөлдөржүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааны үр өгөөжийг аль болохоор дээшлүүлэх хийгээд Монгол Улсын үндэсний хөгжлийн стратегийн хөтөлбөрт Хятад улсын оролцоог гадаад хүчин зүйлийн хувьд оновчтой тодорхойлоход чиглэгдэж байгаа юм.

Дотоод бодлогын судалгаа.

Монголын хятад судлаачид Хятадын гадаад бодлогыг судлахаас гадна мөн дотоод улс төрийн бодлого, нийгэм улс төрийн байдлыг судалсаар ирсэн билээ. Ялангуяа Хятад дахь өөрчлөлт шинэчлэлийн бодлого хэрэгжиж эхэлснээр Хятадын улс төр, эдийн засаг нийгмийн асуудал улам эрчимтэй судлагдаж хятад судлалын чухал чиглэлийн нэг болоод байна. Тухайлбал: ШУА-ийн ОУСХ энэ чиглэлээр хэд хэдэн төсөл хэрэгжүүлэв. Тухайлбал: “БНХАУ-ын өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого” төслийг нэрлэж болох бөгөөд тус төслийн хүрээнд анх удаа өөрчлөлт шинэчлэлийн үеийн Хятад орныг цогцоор нь авч судлах гэсэн оролдлого хийж, хятад судлаачид Хятад дахь өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлогын явц, улс төрийн тогтолцоонд явагдаж буй шинэчлэл, гадаад хөрөнгө оруулалтын хэрэгжилт, улсын өмчийн үйлдвэрийн байдал, хувь заяа, үндэсний цөөнхийн бүс нутгийн нийгэм-эдийн засгийн байдал, үндэсний асуудал, Хятадын гадаад бодлогын үндсэн чиглэл, Хятад ба их гүрнүүдийн харилцаа зэрэг асуудлыг судалсан болно. Тус төслийн үр дүнд “БНХАУ-ын өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого” /УБ, 1999/ хамтын бүтээл хэвлэгдэн гарчээ. Монголын хятад судлаачид Хятад дахь улс төр, нийгэм эдийн засгийн хүрээнд хийгдэж буй бодлогын чанартай өөрчлөлтийг судалж зохих дүн шинжилгээ хийж байгаа нь Монголын нийгмийн аль ч хүрээнд түүний аль ч шатанд өнөөгийн Хятад улс, түүний хэрэгжүүлж буй бодлого, нийгэмд нь гарч буй бодит өөрчлөлтийн талаар тодорхой ойлголтыг бий болоход тус дөхөм үзүүлдэг юм. Хятадын нийгэм улс төрийн судалгааг хийхдээ юуны өмнө, Монгол Улсын эрх ашгийн үүднээс судалдаг бөгөөд судалгааны сэдвийн сонголт ч энэхүү зорилгод чиглэгдэж байдаг. Тухайлбал: Хятадын бүсчилсэн хөгжлийн стратеги болох Хятадын Баруун бүс нутгийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийн судалгаа нь мөн дээрхи зорилгод чиглэгджээ. Энэхүү судалгааны хүрээнд нийтлэгдсэн зарим

бүтээлүүдийг дурьдваас, Ц.Баатар, И.Баатар (БНХАУ-ӨМӨЗО) “Хятадын баруун бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэх асуудлын тухайд” (“ОУС” сэтгүүл, 2001, №1), Н.Ариунгуа. “БНХАУ-ын Баруун хойд бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэх бодлого ба ӨМӨЗО-ы мал аж ахуйн бүс нутгийн хөгжлийн төлөв” (“ОУС” сэтгүүл 2002, №1), Ц.Баатар “Эдийн засгийн чөлөөт бүс: туршлага, сургамж, чиг хандлага” (“ОУС” сэтгүүл 2004, №8), Н.Ариунгуа “Баруун бүс нутгийг хөгжүүлэх стратеги” (“Өнөөгийн хятад” сэтгүүл 2005, №1), Ч.Батцэцэг “БНХАУ-ын Баруун бүс нутгийн хөгжил дэх ӨМӨЗО” (“Өнөөгийн Хятад” сэтгүүл, 2006, №1), Н.Ариунгуа “Хятадын хилийн бодлого, хил орчмын хамтын ажиллагаа манай улсын хилийн талаар баримтлах бодлогод нөлөөлөх нь” (“ОУС” 2005, №1), Ч.Батцэцэг “Монгол Улсын хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагаа” (“ОУС” 2006, №2), Н.Төмөр “БНХАУ-ын Баруун бүс нутгийн замхарилцааны хөгжлийн талаар товч өгүүлэх нь” (“ОУС” 2002, №2) гм.

Хятадын дотоод бодлогын судалгааны нэг чухал аспект бол Хятадын үндэстний бодлогын судалгаа юм. Хятадын “Соёлын хувьсгал”-ын үеэс улбаалан судлаж ирсэн БНХАУ-ын үндэстний цөөнхийн талаархи судалгааны ажил үргэлжилж байна. Тухайлбал БНХАУ-ын өөрчлөлт шинэчлэлийн бодлого үндэстний цөөнхийн бүс нутагт хэрхэн тусгалаа олж, үр өгөөжтэй, ач холбогдолтой болж байгаа, түүний эерэг сөрөг талыг судлаж байна. Мөн БНХАУ-ын Баруун бүс нутгийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд үндэстний цөөнхийн өөртөө засах орнууд багтсан нь манай хятад судлаачдын бас нэг судлагдахуун болсон юм. Баруун бүс нутгийн хөгжлийн стратегийн хүрээнд үндэстний цөөнхийн районуудын хөгжлийн асуудлуудыг хөндсөн бүтээлүүдийг бид дээр дурдсан болно.

Монгол, Хятад хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа улам өргөжин тэлж буй энэ үед Өвөр Монгол нь Монгол, Хятадын харилцааны хөгжилд багагүй үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ч.Батцэцэг “Монгол-Хятадын харилцаанд ӨМӨЗО-ы эзлэх байр суурь (XX зууны дунд үеэс XXI зууны эхэн)” нэртэй нэгэн сэдэвт зохиол бичиж 2004 онд эрдмийн зэрэг хамгаалсан нь хоёр орны харилцааны судалгаанд чухал ач холбогдолтой болсон билээ.

Монголын хятад судлаачид БНХАУ-ын үндэстний цөөнхийн асуудал түүн дотроо өвөр монголчуудын түүх, нийгэм соёлын асуудлыг ихэд сонирхон судалж ном, бүтээлээ хэвлүүлсэн байна. Тухайлбал: Ж.Өлзий “Өвөр Монголын Өөртөө Засах Орны зарим үндэстэн, ястны гарал үүсэл, зан заншил” (УБ, 1990), М.Зэнэ “Өвөр Монгол: өчигдөр, өнөөдөр” (1990)

ном бичиж, Ц.Баатар “Хятадын улс төрийн өөрчлөлт дахь Өвөр Монголын нийгэм-эдийн засгийн хөгжлийн зарим асуудал (1978-1992)” сэдвээр 1993 онд эрдмийн зэрэг хамгаалсан. Мөн ШУА-ийн ОУСХ-ээс эрхлэн “Хятад дахь монголчууд” (УБ, 1996) хамтын бүтээл хэвлүүлжээ.

Ийнхүү БНХАУ-ын үндэстний цөөнхийн асуудлыг судлахдаа гол төлөв Монгол Улстай хил дамнан орших угсаа гарваль, хэл бичиг, түүх, соёл, зан заншил нэг монгол үндэстнийхээ тухайд судлаж иржээ. Цаашид БНХАУ-ын бусад үндэстний цөөнхийн бүс нутагт явагдаж буй өөрчлөлт шинэчлэл, хоёр орны хилийн худалдаа, хил орчмын орон нутгийн хамтын ажиллагаа, мал аж ахуй, хөдөө аж ахуй, байгаль экологи, хөрөнгө оруулалт гэх мэт асуудлыг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна.

Хятад судлал сүүлийн үед олон улс судлалын хүрээнд судлагдахаас гадна орон судлалын чиглэлээр тодорхой хэмжээгээр судлагдаж байгаа бөгөөд энэ төрлийн судалгаа гол төлөв ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн болон бусад их дээд сургуулиудад явагдаж байна. Сүүлийн жилүүдэд энэ чиглэлээр хийсэн ажлыг тоймлон хүргэвэл “Өнөөгийн Хятад орон” (УБ.1996), “Өвөр Монголын Өөртөө Засах Орон” (УБ.1998) зэрэг хамтын бүтээл болон энэ чиглэлээр “Дорнодахины судлалын асуудал”, “Олон улс судлал” зэрэг сэтгүүлд гарсан олон арван өгүүлийг дурьдаж болно. Мөн их дээд сургуулиудад тухайлбал: МУИС-ийн Гадаад хэл соёлын сургуульд Хятадын орон судлалын сургалт нэлээд эрчимтэй явагдахын зэрэгцээ энэ чиглэлээр магистрын хэмжээнд судалгаа хийх болжээ. Нөгөөтэйгүүр хоёр орны харилцаа улам бүр өргөжин тэлж буй өнөө үед хятад хэл, түүх, соёлыг сонирхон судлагчид, ажил төрөл, бизнесийн шугамаар Хятад улстай холбоотой байгууллага хүмүүсийн тоо олширч улмаар эрдэм шинжилгээ, сургалт, нийгмийн аль ч талаас авч үзсэн эрдэм шинжилгээ-танин мэдэхүйн чиглэлтэй хятад судлалын дагнасан тогтмол хэвлэл гаргах бодит эрэлт хэрэгцээ бий болсон юм.

1990 онд ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн дэргэд Монголын Хятад Судлаачдын Холбоо байгуулагдснаар “Арга билиг” хэмээх сонинтой болж, хятад судлаачид хятадын талаархи танин мэдэхүйн сонирхолтой сэдвээр өгүүлэл, орчуулга нийтлүүлж олны таашаал хүртэж байсан боловч өдгөө үгүй болжээ. Харин Хятад судлалын чиглэлээр бие даасан шинжлэх ухааны хялбаршуулсан судалгаа, сурталчилгаа, танин мэдэхүйн “Өнөөгийн Хятад” нэртэй сэтгүүлийг ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгээс эрхлэн 2005 оноос (жилд 2 удаа) хэвлэн гаргаж, хятадын түүх, соёл, уран зохиолыг

олны хүртээл болгож байна. Энэ сэтгүүл нь манай найрамдалт хөрш БНХАУ-ын тухай өргөн мэдээлэл, судалгааны материалтай уншигч олныг танилцуулж, хоёр орны харилцааг улам бэхжүүлэхэд чиглэгдэж буй анхны бие даасан хэвлэл гэдгээрээ онцлог юм.

Хятад судлалын нэг чухал салбар бол түүх судлал юм. Хятадын түүхийн судалгаа манай улсад өөрийн гэсэн онцлогтой хөгжиж ирсэн ба энэ нь хятад судлаачид Хятадын түүхийг судлахдаа Монголын түүхтэй ямарваа нэг хэмжээгээр холбогдол бүхий асуудлыг хөндөн судалсаар ирсэнтэй холбоотой юм. Юуны өмнө Монголын түүхийн холбогдол бүхий хятадын эрт, дунд зууны үеийн түүхэн сурвалж бичгийн судалгааг нэрлэж болно. Энэ чиглэлээр гарсан бүтээлүүдийг дурьдваас Ж.Баясах “Өмнөд Сүн улсын элч нарын тэмдэглэл XIII зууны Монголын түүх угсаатны зүйн сурвалж болох нь” (1989), Ж.Баясах “XIII зууны Монголын түүхэнд холбогдох хятад гол сурвалж бичгүүд” диссертаци зохиол (УБ.2004) болон Н.Ариунгуагийн “Чань Чунь бумбын Өрнө зүгт зорчсон тэмдэглэл” (УБ.1997) хэмээх зохиолын орчуулга зэрэг юм. Дээрхи хятадын сурвалж бичгүүд нь Монголын дунд зууны үеийн түүх, монголчуудын аж ахуй, зан үйлийн талаар тодорхой мэдээ бүхий чухал сурвалж бичгүүд бөгөөд тэдгээрийг орчуулж судалсан явдал бол цаашид Хятадын түүхэн сурвалж бичгүүдийг монгол хэлнээ орчуулж эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах нөр их ажлын эхлэлийг тавьснаараа чухал ач холбогдолтой юм. Энд тэмдэглэхэд манай түүхчид Ч.Далай, Л.Жамсран, Н.Ишжамц, Г.Сүхбаатар, Ц.Хандсүрэн, Н.Ариунгуа, Ж.Баясах нарын эрдэмтэд монголын түүхийн холбогдол бүхий хятад сурвалжийн мэдээ сэлтэд тулгуурлан Монголын тодорхойн үеийн түүхийн судалгааг баяжуулахад чухал хувь нэмэр оруулсныг тэмдэглүүштэй. Сүүлийн үед ч монголын түүхэнд холбогдох хятадын сурвалж судалгааны мэдээ сэлт эрдэм шинжилгээний эргэлтэнд орсоор байгаа бөгөөд тухайлбал: Н.Төмөрийн бичсэн “Их Монгол улсын төрийн зүтгэлтэн Елюй Чуцай” (УБ. 2006) диссертаци зохиолыг дурьдаж болно.

Монголд Хятадын түүх судлалын хүрээнд хийгдэж буй бас нэгэн чиглэл бол яах аргагүй хоёр орны харилцааны түүхийн судалгаа юм. Хэдий манай түүхчид Монгол-Хятадын харилцааны түүхийн бүхий л үеийг монголын түүхийн судалгааны хүрээнд тодорхой хэмжээгээр тусгасан боловч хоёр орны харилцааны түүхийг тусгайлан судалсан явдал үгүй бөгөөд Н.Ариунгуагийн “XIV-XVI зууны Монгол-Хятадын харилцаа” (УБ.1996) ном нь энэ чиглэлээр бичсэн анхны нэгэн сэдэвт зохиол юм. Тус зохиолд монгол хятад хэлээрхи сурвалж бичгүүдийн мэдээ сэлтэд

тулгуурлан хоёр орны харилцааны шинж чанар, Монголын талаар явуулж байсан Хятадын гадаад улс төрийн бодлого, тухайн үеийн Монгол улсын гадаад улс төрийн статусыг тодорхойлохыг оролджээ.

Хятадын түүх бичлэгт Монголын түүх хэрхэн тусгагдаж байгаа талаархи судалгаа нь Хятадын түүх судлалаар хийгдэж буй бас нэг чухал чиглэл юм. Энэ чиглэлийн судалгаа нь Монголын хятад судлалд чухал байр эзэлдэг бөгөөд чингэх нь юуны өмнө Хятадын “соёлын хувьсгал”-ын үеэс улбаатай Хятадын түүх бичлэгт манай улсын түүхийг Хятадын түүхийн хавсрага болгох хандлага байдгаар тайлбарлагдана. Нөгөөтэйгүүр Хятад улсад сүүлийн үед Монголын түүх судлал эрчимтэй хөгжиж байгаатай ч холбоотой юм. Энэ чиглэлээр гарсан зарим бүтээлүүдийг дурьдвал Н.Алтанцэцэг “Монголын ард түмний манжийн эсрэг үндэсний эрх чөлөөний түүхийг БНХАУ-ын түүх судлалд тусгаж байгаа нь” (М.1985), Н.Алтанцэцэг “1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний тэмцлийн түүхийг БНХАУ-д судалж байгаа нь” (1911 оны үндэсний хувьсгалын 90 жилийн ойд зориулсан э/ш-ний бага хурал УБ. 2001), Н.Ариунгуа “Чингис болон Монголын эзэнт гүрний судалгаа Хятадын түүх бичлэгт” (Чингис хааны мэндэлсний 840 жилийн ойд зориулсан э/ш-ний бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. УБ. 2003) зэрэг юм.

Хятадын түүхийн судалгаа тодорхой хэмжээгээр хөгжиж байгаагийн бас нэг бодит жишээ бол манай хятад судлаачид Хятадын түүхийн талаар зохиол бичсэн явдал юм. Тухайлбал: Н.Ишжамц “БНХАУ-ын түүхийн товч тойм (нэн эртнээс 1999 он)” (УБ.1999), Ж. Баясах “Хятадын товч түүх” (УБ.2002), Д.Наран “Хятадын түүх ХХ зуун” (УБ.2002) зэрэг зохиолуудыг дурьдаж болно. Эдгээр зохиолууд нь хятадын түүхийг өргөн олонд танилцуулахаас гадна их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт орж, сурах бичгийн хувьд хэрэглэгдэх чухал бүтээлүүд юм.

Хятад судлалд утга зохиол, соёл, урлагийн чиглэлийн судалгаа мөн хөгжиж байна. Монгол, Хятад хоёр улс өнө эртнээс эдийн болон утга соёлын харилцаатай явж ирсэн түүхэн уламжлалыг өдгөө манай хятад судлаачид өвлөн авч үргэлжлүүлэн хятадын утга зохиолын шилдэг бүтээлээс орчуулан, шинэ үеийн уран зохиол, орчин цагийн уран зохиолын өрнөл хөгжлийн асуудлаар судалгаа хийх болжээ. Тухайлбал: Л.Манлажав “Монголын нууц товчоон дахь хятад үсэг ашиглан ярьдаг үеийн монгол хэлний авиалбарын зүй тогтол” сэдвээр 1973 онд эрдмийн зэрэг хамгаалж, Ч.Таамаа Бээжингийн Их сургуульд “Хятадын шинэ үеийн уран зохиол дахь хүн тэрэгчийн дүрийн судалгаа” сэдвээр

1997 онд диссертаци зохиол бичиж, Я.Ганбаатар “Нанхиадын эртний уран зохиол” номоо 1998 онд хэвлүүлж, Ц.Базаррагчаа “Шүлэглэлт ном”-оо орчуулж, 1999 онд хэвлүүлсэн, Ш.Эгшиг “Хятадын сонгодог зохиолын орчуулга хийгээд хэлний онцлог” ганц сэдэвт зохиол бичиж 2000 онд эрдмийн зэрэг хамгаалсан байна.

Доктор Ц.Базаррагчаа “Удирдагч хүний яруу хэрэглүүр” өгүүлэлд “Дорнодахины улс орны удирдагч хүн, эх хэлнийхээ найруулгыг ихэд эрхэмлэдэг, хэлний яруу хэрэглүүрийг машид дээдэлдэг өнө цагийн уламжлалтай байжээ. Эртний энэ уламжлалыг дөнгөж саяхны гэхээр жишээг Монголын хувьсгалын удирдагчийн нэгэн Д.Сүхбаатар, Хятадын удирдагч Мао Зедуны хэлний яруу хэрэглүүрийг хэрхэн чадамгай эзэмшсэн”⁷ болохыг нотлохыг хичээсэн байна.

Хятадын шашин шүтлэгтэй холбоотой өгүүлийг доктор З.Лонжид “Өвөр Монголд христийн шашин нэвтэрсэн түүхийг мөшгөн нягтлахуй” эрдэм шинжилгээний өгүүлэл (УБ, 2005) нийлүүлж, гүн ухаан, сэтгэлгээний талаархи судалгааг хятад судлагч М.Чимэдцэеэ хийж хэд хэдэн ном орчуулан хэвлүүлж монголын уншигч ард түмний хүртээл болгов. Тухайлбал хятад судлаач М.Чимэдцэеэ Күнзийн “Шүүмжлэл өгүүлэл” номыг монгол хэл рүү орчуулж хэвлүүлэхдээ эртний хятад хэлнээс орчин цагийн хятад хэлнээ хөрвүүлсэн номууд, тайлбар, бусад тайлбар, ном сэлтийг харьцуулан үзсэн байна. Тэрбээр “Шүүмж өгүүлэл” номынхоо оршилд “Күнз хэмээх нэрийг дурдахул Хятадын эртний гүн ухааны сэтгэлгээ, үндэсний уламжлалт соёл хэмээх утга лугаа шууд холбогдоно. Хятадын үндэсний уламжлалт утга соёлын тухай яриваас Күнзийн гүн ухааны сэтгэлгээ, соёлыг дурдах хэрэгтэй болно. Тиймээс дэлхий дахинаа Күнзийн соёл, гүн ухааны сэтгэлгээг Хятадын төдийгүй, хүн төрөлхтөний сэтгэлгээ, соёлын нэгэн охь дээж хэмээн үнэлж, Күнзийг дэлхийн суут арван их сэтгэгчийн нэг хэмээн зүй ёсоор нэрлэдэг гэнэм”⁸ гэжээ.

Улмаар орчуулагч, хятад судлаач М.Чимэдцэеэ “Сүнзийн дайтахуйн ухаан” /УБ, 2005/ хоёр дахь номоо орчуулж хэвлүүлсэн нь өнөөгийн зах зээлийн эдийн засаг, нийгмийн байдалд нийцсэний зэрэгцээ хятадын түүх соёлыг сонирхсон судлаачид, хятад хэл бичигт суралцагсад, түүнчлэн хятадын утга соёлын өв сангаас үзэж мэдэхийг хүссэн өргөн олон уншигчдад ач холбогдолтой болжээ. М.Чимэдцэеэ хятадын уран зохиолын орчуулгыг дагнан ажиллаж, тэр чиглэлээр судалгаа хийсний үндсэн дээр “Хятадын сонгодог уран зохиолын монгол орчуулгын уран чадварын асуудалд” сэдвээр 2006 онд докторын зэрэг хамгаалсан юм.

Орчин үед манай кино театр, радио-телевизээр хятадын эртний сонгодог зохиол, түүхэн сэдэвт зохиолоор хийсэн уран сайхны кино, телевизийн олон ангит кино-жүжиг ихээр гарах болжээ. Түүнийг монгол хэлнээ хөрвүүлэн үзэгч олондоо толилуулах ажлыг хятад судлаач, орчуулагч Д.Болдбаатар голлон гүйцэтгэж байгаа бөгөөд “Хятад киноны орчуулгын хэлц үгийн оноолтын уран чадварын асуудал” сэдвээр 2005 онд эрдмийн зэрэг хамгаалсан юм.

Урлаг судлалын ухааны доктор, хөгжим судлагч Л.Эрдэнэчимэг хятадын эртний сурвалж бичиг Нанхиадын Гүн гэрийн хатагтай Цай Вэнжи гүнжийн зохиосон “Цуурын арван найман аялгуу” хэмээх яруу найргийн бүтээлийг өвөр монголын судлагч нартай хамтран судалж, түүний шүлгээс эх авч зохиогдсон дуу, хөгжмийн аялгуу, уран зураг, жүжгийн зохиол, түүх бичлэгийн талаар өөрт буй эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан дуу, шүлгийн монгол орчуулгыг толилуулан “Гүн гэрийн хатагтайн “нүүдэлчдийн цуурын арван найман аялгуу” (УБ.2002) номоо хэвлүүлсэн байна.

Хятадад өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого явуулснаар сүүлийн хорь гаруй жилд хоёр орны найрсаг харилцаа өргөжин тэлж, хөрш Хятад орныхоо олон мянган жилийн түүхтэй, хятадын ард түмний соёлын өв сан, зан заншил, ардын уламжлал, уран бичлэг, баяр ёслол, мэндлэх хүндлэх ёс гэх мэтээр судлан, танин мэдэх, оюуны хэрэгцээ манай оронд ихээр нэмэгдэж ирсэн юм. Энд Г.Аким “Цэцэн билигт хүрэх мөр” хэмээн нэрлэсэн өгүүлэлдээ Хятадын уран бичлэгийн түүхээс өгүүлж (“Ил Товчоо” сонины 1993 оны VIII.20-IX.3.22 (91)) дугаарт нийтэлсэн, мөн Я.Ганбаатар “Нанхиадын уран бичлэг” өгүүлэл (“Ил товчоо” сонин 1995.12-рсарын №35) нийтлүүлж, оюутан Д.Ундрах “Монгол, Хятадын уран бичлэгийн хүмүүншлийн ач холбогдол хийгээд өнөөгийн хэрэглээ” сэдвээр бичсэн магистрын ажил, Г.Гунгаа “Хятадын ардын эмнэлэг үүсч хөгжсөн түүх” өгүүллийг (“Зүүн хойд Ази” сэтгүүл) зэргийг дурьдах нь зүйтэй боловуу.

Одоо Монгол Улсад ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс гадна МУИС-ийн ОУХС, ГХСС, МХСС-ийн Хятад хэлний тэнхим, МУБИС-ийн ГХДС-ийн Дорнодахины хэлний тэнхим, Хүмүүнлэгийн их сургууль болон бусад хувийн хэвшлийн их, дээд сургуулиудад хятад хэлний анги тэнхим нээгдэж, тус салбарын оюутнууд хятад судлалаар төгсөх оюутны диплом, магистрийн ажил хийх болжээ. Чингэхдээ гол төлөв хятадын түүх, соёл, хэл, зан үйлийг судлахдаа Хятадад буй монголын түүх соёлтой холбоотой аливаа сэдвээр харьцуулсан судалгаа хийх явдал нэлээд түгээмэл байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал: ШУА-ийн Хэл зохиолын

хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Мижиддорж Хятад хэлэнд орсон монгол үгийн талаар судалгааг анх эхлүүлж байсан бол сүүлийн үед монгол хэлэнд орсон хятад үгсийн талаар нэлээд сонирхон бичих болсон. 90-ээд оноос хойш Я.Ганбаатар “Хятад хэлэнд орсон хятан үг” (“Эрдэм шинжилгээний бичиг”, 1997 №10/122/ т.20), оюутан Л.Бадамхорол Ц.Базаррагчаагийн удирдлагаар “БНХАУ дахь газар усны монгол нэр”, Ш.Эгшиг “Хятадын Шаньдун муж дахь Монгол үндэстний гэрэлт хөшөөний учир” өгүүлэлдээ: “Монголчууд бидний өвөг дээдэс дэлхий дахины түүхнээ ул мөрөө гүнзгий үлдээсэн эртний соёлт үндэстний нэг нь гарцаагүй мөн хийгээд Ази Европыг дамнасан тэр агуу их өргөн уудам нутагт монгол туургатны хэл бичиг, утга соёл, шашин суртал, эд өлгий, овог төрөл, түүх домгийн гэх зэрэг няцаашгүй баримт сэлт олдож буй нь үүнийг нотолж, өдгөө дэлхий соёлын цогцод салшгүй нэгэн хэсэг нь болон оржээ”⁹ хэмээн бичжээ. МУИС-ийн оюутан Ж.Энхбилгүүн “Монгол, Хятадын ард түмний ёс заншил дахь цээрлэх ёсыг харьцуулан судлах нь” сэдвээр магистрын ажил бичиж, магистр Л.Солонго “Хятад хэлнээ харь үг авдаг арга зүй” (“Эрдэм шинжилгээний бичиг” 2005) гм өгүүлэл тус тус хэвлүүлжээ.

МУИС-ийн магистр Л.Солонго “Эртний болон орчин цагийн хятад хэлний хийсвэр үгийн тухай” судалгаа хийж бичсэн өгүүлэлдээ “Эртний хятад хэл бол мянга гаруй жилийн өмнө хэрэглэгдэж байсан болохоор орчин цагийн хятад хэлтэй нэлээд зөрүүтэй, ялангуяа эртний хятад бичгийг шууд монголоор буулгахад хэцүү байдаг. Манай монгол орчуулга бол ихэнхдээ уг зохиолын “тайлбар орчуулга”-аас дамжин орчуулагддаг. Эртний хятад хэлэнд “тайлбар” хийсэн сүүлийн үеийн хүмүүсийн “орчуулга” нь хэдийгээр гол үндэслэлийг хангаж өгсөн боловч бас алдаатай зүйл цөөн бус байдаг тул эртний хятад бичгийг монголчлоход “давхар хяналт” хийх нь чухал” гэдгийг онцолсон юм. (Монгол судлал. “Эрдэм шинжилгээний бичиг” 2005 Боть XXV. 248 т.63-67).

Манай улс дахь Хятад судлалын бас нэг чухал чиглэл бол хятад хэл судлал, толь бичиг, сурах бичиг зохиох, орчуулгын зэрэг ажил юм.

МУИС-ийн Хятад хэлний тэнхимийн багш Чой.Лувсанжав, Ц.Базаррагчаа, Г.Гунгаа нар “Хятад монгол толь бичиг” (40хх) бичиж бэлэн болгосон авч хэвлэгдээгүй өнөөг хүрчээ. Харин Ц.Базаррагчаа 1985 онд “Орчуулгын хичээлийн сурах бичиг” хэвлүүлсэн байна. Сүүлийн үед хятад хэл сонирхогчдын тоо олширсон холбогдуулан монгол, хятад, хятад монгол толь бичиг, ярианы дэвтэр, жуулчны гарын авлага олноор хэвлүүлэх болжээ. Д.Болдбаатар “Хятад-Монгол

толь” (2002), “Монгол-Хятад толь” (УБ.2003), Ц.Ганбаатар, А.Гаваа нар “Шинэ Хятад-Монгол толь” (УБ.2003) зохиожээ.

Монгол, хятад хэлний харьцуулсан судалгааны ажлыг хэл шинжлэлийн эрдэмтэн судлаачид хийж, холбогдох ном, толь бичиг, сурах бичиг, гарын авлага хэвлүүлэх болов. Тухайлбал: Д.Наран “Хятад хэлний сурах бичиг” 1,2,3 орчуулж, Ч.Таамаа, Д.Бадмаанямбуу, Жай Сюнь “Хятад хэлний үгийн сан”, “Хятад хэлний хэлзүй” зэрэг сурах бичиг, Ц.Базаррагчаа “Хятад монгол орчуулгын харьцуулсан судалгаа”, “Орчуулгын сурах”, “Монгол Хятад хэлний орчуулга зүй”, Ч.Таамаа, Г.Элдэв-Очир “Хятад хэлний товч авиа зүй”, Д.Наран “Хятад хэлний хэлмэрчлэхүй хичээлийн сургалтын онцлог, тохиолдох бэрхшээл”, Ч.Таамаа “Хятад хэлний сурмал оновчтой шинж”, Г.Элдэв-Очир “Ханз үсгийн үүсэл” зэрэг эрдэм шинжилгээ судалгааны өгүүлэл бичиж нийтлүүлсэн нь оюутан сурагчдын гарын авлага болж байна. Ч.Таамаа “Хятад хэл заах арга зүйн зарим асуудал өгүүлэлдээ: “Хятад хэл сурахад авианы зөв дуудлага, бичлэг, уншиж ярих чадварыг хослон сургах арга барил чухал байдаг учраас аль болохоор сайн хослуулан сургах, сурах ажлыг хийхийн учрыг анхаарахыг чухалчлаад, нэгд, хөгийг чухалчлан үздэггүй, хоёрт, дөрвөн хөгийн ялгааг сайн мэддэггүй, үгийн хөгийг цээжилдэггүй зэрэг дутагдал оюутнуудад их байдаг. Иймээс унших, бичих, сонсох, ярианы дадал маш чухал”¹⁰ гэжээ.

Нөгөөтэйгүүр манай улсад Хятад хүний нэр, газар усны нэр, оноосон нэр зэргийг сонин хэвлэл, радио телевиз, мэдээллийн хэрэгслээр өдөр бүр бичин, нийтлэх явдал улам бүр нэмэгдсээр байгаатай холбогдуулан монгол, кирилл үсгээр үнэн зөв галиглан буулгах шаардлага өнөөдөр чухал болж байна. Энэ тухай манай хятад судлаачид өөрсдийн санал бодлоо илэрхийлсэн өгүүлэл нийтэлж бичиж ирсэн. Тухайлбал: Л.Жамсран “Хятад, англи, орос, монгол бичгээр хятад үг галиглах харьцуулсан лавлах” (УБ.1999), ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс эрхлэн гаргасан “Өнөөгийн Хятад орон” ном (УБ,1996), Б.Гэрэлт-Ирээдүй “Хятад үгийг кирилл үсгээр галиглах тухайд” Хэлэхэд хэл хугармаар (“Ил товчоо” сонин, 1998), Ш.Бадраабат “Хятад үгийг монгол хэлэнд зөв галиглах тухайд” (“Дорно-Өрнө” сэтгүүл. 1998 №1,2), “Рэнь минь рибало юу? Жэнь минь жибао юу?” (“Ардын эрх” сонин 1998), Ц.Ганбаатар “Хятад хэлний төв аялгууны авианы галигийг монгол кирилл үсгээр галиглах асуудалд” (МХСС-ийн “Эрдэм шинжилгээний бичиг” 2005. Боть XXIV) зэрэг өнөөгийн тулгамдсан асуудлаар өөрсдийн саналыг дэвшүүлсэн өгүүлүүд

нийтлүүлжээ. Гэвч энэ асуудлаар манай хятад судлаачид өнөөг хүртэл нэгдсэн нэг үзэл баримтлалд хүрч чадаагүй байгаа нь туйлын харамсалтай. Үүний гол шалтгаан нь ЗХУ-д хятад хэлний мэргэжлээр бэлтгэгдсэн боловсон хүчин орос галигийг гол болгон ашиглаж ирсэн ба МУИС-ийн хятад хэлний ангийг төгсөгчид хятад хэлний дуудлага, төв аялгууны авиаг монгол хэлний цагаан толгойн дуудлагатай илүү дөхөм болгож монгол крилл үсгээр галиглах болсонтой холбоотой юм. Иймд манай хятад судлаачдын өмнө тавигдаж буй тулгамдсан асуудал бол нэн тэргүүнд хэл шинжлэлийн үндэслэлтэй, авианы нэгдсэн зөв дуудлага, галигтай болох ажлыг даруй хийж, цэглэх цаг нэгэнт болжээ.

Ийнхүү Монгол дахь хятад судлалын түүх, өнөөгийн хөгжлийн байдлыг дүгнэвээс энэхүү судалгаа нь дагнасан хятад судлал гэхээсээ илүү ямарваа нэгэн хэмжээгээр Монголтойгоо холбон харьцуулсан судалгааны чиглэлээр хөгжиж иржээ. Үүнийг тухайн үеийн Монголын нийгмийн хөгжлийн захиалга хэмээн тайлбарлаж болох мэт. Гэвч хятад судлалын цаашдын зорилго бол хөрш Хятад орныг олон улс судлал, орон судлалын хүрээнд гүнзгийрүүлэн судлах, чингэхдээ нийгэм, улс төр, эдийн засаг, гадаад бодлогоос гадна түүх, соёл, уламжлалт нийгмийн сэтгэлгээ, төр ёсны уламжлал, гүн ухаан зэрэг чиглэлээр судлах шаардлагатай бөгөөд чингэх нь манай улс Хятад оронтой харилцах харилцаагаа улам шинжлэх ухааны үндэслэлтэй болгох практик, танин мэдэхүйн чухал ач холбогдолтой юм.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Б.Ринчен. Монгол бичгийн хэлний зүй УБ.1964.т.216
2. Б.Ринчен дээр дурьдсан ном. т.60
3. Б.Ринчен. Монгол хэлний бичгийн зүй. УБ.1964. т.37,194
4. Liu Wu –Chi. Confucius, His Life and Time, New York, 1955
5. “Мөнх гийгүүлэгч дэнлүү”, УБ.1962
6. Уг номын т. 51
7. Ц.Базаррагчаа. “Удирдагч хүний яруу хэрэглүүр”. МУИС-ийн ГХСС-ийн “Эрдэм шинжилгээний бичиг” 2006 №258 т.24
8. М.Чимэдцэеэ. “Шүүмжлэл өгүүлэл”, УБ, 2005
9. Ш.Эгшиг. “Хятадын Шаньдун муж дахь Монгол үндэстний гэрэлт хөшөөний учир”. “Эрдэм шинжилгээний бичиг” т.149. 1999 он
10. Ч.Таамаа. “Хятад хэл заах арга зүйн зарим асуудал”. МУИС-ийн ГХСС-ийн “Эрдэм шинжилгээний бичиг” 2006, №258 т.166